

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 4/04

Арвайхээр

Судалгааны ажил зохион байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 13.2 дахь заалт, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.11 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын талаарх хүн амын дундах мэдлэг, хандлага, дадал"-ыг судлах судалгааны ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, "Судалгааны арга, аргачлал"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Судалгааг 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж, үр дүнг тайлагнахыг Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга (М.Золзаяа)-д даалгасугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 03 дугаар сарын 03-ны
өдрийн 404 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



“КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ТАЛААРХ ХҮН
АМЫН ДУНДАХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДАЛ”-ЫН
СУДАЛГААГ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Д/д	Овог	Нэр	Байгууллага	Албан тушаал
1.	Мангалжав	Золзаяа	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга, Судалгааны багийн ахлагч
2.	Сүхээ	Дуламсүрэн	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн
3.	Цэрэндорж	Сонинбаяр	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн
4.	Мөнхбат	Ганцэцэг	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн
5.	Болоо	Долзодмаа	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн
6.	Батжаргал	Оюунчимэг	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн
7.	Цэдэн содном	Рэгзэдмаа	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн
8.	Энхбаатар	Лхагвадулам	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн
9.	Мягмар дорж	Дуламсүрэн	ББУ сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
10.	Галхүү	Ганчимэд	Бат-Өлзий сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
11.	Бямба	Дэлгэртогтох	Баянгол сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
12.	Пүрэвдорж	Пүрэвсүрэн	Баян-Өндөр сумын ЭМТ	Их эмч, Судалгааны багийн гишүүн
13.	Батмөнх	Энхцэцэг	Богд сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн

14.	Алагшавай	Энхцэцэг	Бүрд сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
15.	Чогдон	Гурванбаяр	Гучин-Ус сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
16.	Лэгцэг	Балжидмаа	Есөнзүйл сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
17.	Батдорж	Лхагва	ЗБУ сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
18.	Дэрэм	Дэмбэрэлдондов	Нарийнтээл сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
19.	Адъяа	Энх-Оюун	Өлзийт сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
20.	Түндэв	Санлигмаа	Сант сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
21.	Ганхуяг	Ууганзаяа	Тарагт сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
22.	Дорж жанцан	Батцэцэг	Төгрөг сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
23.	Мөнхбаяр	Эрдэнэтуяа	Уянга сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
24.	Ломбо ринчин	Ринчинмаа	Хайрхан дулаан сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
25.	Энхбат	Баярсайхан	Хархорин сумын нэгдсэн эмнэлэг	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
26.	Сандаг	Дулам	Хужирт сумын ЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
27.	Шижээ	Мөнхцэцэг	Нарныдөш ӨЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
28.	Гантуяа	Энхтуул	Түшиг дөлгөөн ӨЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судалгааны багийн гишүүн
29.	Донлиг	Адъяасэрээтэр	Өвөрхангай аймаг дахь Улаан загалмайн нийгэмлэг	Сайн дурын идэвхтэн, судалгааны багийн гишүүн
30.	Нямдорж	Ариунсанаа		Сайн дурын идэвхтэн, судалгааны багийн гишүүн

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 03 дугаар сарын 09-ны
өдрийн 40 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

**“КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ТАЛААРХ ХҮН
АМЫН ДУНДАХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДАЛ”-ЫГ
СУДЛАХ СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ**

УДИРТГАЛ

Судалгааны ажлын үндэслэл:

БНХАУ нь 2019 оны сүүлээр эндэгдэл өндөртэй, уушгины үрэвсэл тархаж эхэлсэн тухай ДЭМБ-д мэдээлсэн. Энэ нь 21-р зуун гарсаар коронавирус хүн төрөлхтөнд цар тахлын аюул заналыг гурав дахь удаагаа үзүүлсэн тохиолдол болсон. Шинэ коронавирусээр сэдээгдсэн өвчнийг ДЭМБ-аас КОВИД-19 хэмээн нэрлэж, 2020 оны 3 дугаар сарын 11-нд цар тахал гэж зарласан бөгөөд 2022 оны 03-р сарын 1-ний өдрийн байдлаар Дэлхийн 216 улс орон, дэвсгэр нутагт тархан 434 сая гаруй хүнийг өвчлүүлж, 5.944.342 хүн нас барсан, Монгол улсад 908.157 хүн өвчилж, 2096 хүн нас бараад байгаа бол Аймгийн хэмжээнд 22367 хүн өвчилж 61 иргэн нас барсан байна. (ДЭМБ 2022 оны 2-р сар)

Судалгаагаар Ковид-19 халдварын үед тархалтыг зогсооход дан ганц дархлаажуулалт бус бусад нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахгүй бол халдвар тархах эрсдэл өндөр гэж тогтоосон байна.

КОВИД-19-ын цар тахал нийтийн дунд тархахад хүн амын зан үйлээс ихээхэн хамаарах бөгөөд өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь нэн тэргүүний ажил болно. Хүн амын коронавируст халдварын талаарх мэдлэг, хандлага, дадал, ойлголтыг тогтоох нь урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг эрчимжүүлэхэд ихээхэн тус болно.

Иймээс коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаарх хүн амын мэдлэг, хандлага, урьдчилан сэргийлэх зан үйл, ойлголт, мэдээллийн хэрэгцээг тодорхойлж хүн амыг хэрэгтэй мэдээллээр хангах, урьдчилан сэргийлэх мэдлэг, дадлыг нэмэгдүүлэх мэдээллийн чанар хүртээмжийг сайжруулах шаардлага тулгамдаж байна.

Судалгааны ажлын зорилго

Аймгийн хэмжээний хүн амын дундах коронавируст халдвар /КОВИД-19/-ын талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлж, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хүн амыг нотолгоонд тулгуурласан мэдээллээр хангах

Судалгааны ажлын зорилт

- Хүн амын дундах коронавируст халдвар /КОВИД-19/-ын талаарх мэдлэгийг үнэлэх
- Судалгаанд хамрагдсан хүн амын цар тахлын үеийн хандлагыг судлан тогтоох
- Коронавируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх хүн амын зан үйлийг судлах
- Судалгаанд хамрагдсан хүн амын цар тахлын үеийн эрсдэлийн ойлголт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байдлыг тандах
- Судалгааны үр дүнд үндэслэн зөвлөмж боловсруулж түгээх

Судалгааны ажлын таамаглал

Хүн амын дундах коронавируст халдвар /КОВИД-19/-ын талаарх мэдлэг, хандлага, дадал нь хүн амын насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, байршлаас хамааран ялгаатай байна.

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА АРГА ЗҮЙ

Судалгааны ажлын арга ба загвар

Хүн амын дундах коронавируст халдвар /КОВИД-19/-ын талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгаанд нэг агшингийн судалгааны загвараар тоон болон чанарын аргыг ашиглана. Судалгааг Коронавируст халдварын талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадал, ойлголтыг тогтоох үндэсний судалгааг өөрийн орон нутгийн нөхцөлдл тохируулан ашиглалаа.

Судалгааны ажлын хамрах хүрээ, түүвэр

Аймгийн хэмжээний нийт хүн ам (n=116785)-ын 2.16 хувиас нь буюу 2523 хүн амыг хамруулна.

№	Сумын нэр	Нийт хүн ам	Түүвэр	Хамрагдах хүн ам
1	Арвайхээр сум	33743	2.16%	729
2	Баруунбаян-Улаан сум	2784	2.16%	60
3	Бат-Өлзий сум	7570	2.16%	164
4	Баянгол сум	3825	2.16%	83
5	Баян-Өндөр сум	3647	2.16%	79
6	Богд сум	5803	2.16%	125
7	Бүрд сум	2905	2.16%	63
8	Гучин-Ус сум	2197	2.16%	47
9	Есөнзүйл сум	2857	2.16%	62
10	Зүүнбаян-Улаан сум	3859	2.16%	83
11	Нарийнтээл сум	3620	2.16%	78
12	Өлзийт сум	2389	2.16%	52
13	Сант сум	3534	2.16%	76
14	Тарагт сум	3216	2.16%	69
15	Төгрөг сум	2731	2.16%	59
16	Уянга сум	9542	2.16%	206
17	Хайрхандулаан сум	3504	2.16%	76
18	Хархорин сум	12256	2.16%	265
19	Хужирт сум	6803	2.16%	147
	Нийт	116785	2.16%	2523

Чанарын судалгаанд сум бүрээс 4 бүлэг /малчин, өсвөр насны хүүхэд, ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүсь хөдөлмөр эрхлэдэггүй/-ийн 76 иргэнийг санамсаргүйгээр сонгон авч ярилцлагын аргаар судалгааг авна. Мөн 19 сумаас 1 өрхийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч ажиглалтын судалгааг явуулна.

Судалгаанд хамруулах хүрээ

Асуумж судалгаа: Урьдчилан боловсруулсан асуумжийн дагуу иргэдтэй утсаар холбогдож судалгааг авна. Нийт судалгаанд оролцогчдын 25 хувь нь малчин, 25 хувь нь өсвөр насны хүүхдүүд, 25 хувь нь төрийн албан хаагчид, 25 хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэн байхаар тооцож, хүн амын нэгдсэн

бүртгэлээс санамсаргүй түүврийн аргаар 10 хүний давтамжтайгаар судалгаа авах иргэдийн жагсаалтыг гаргаж судлаачдад хүргүүлнэ.

Чанарын судалгаа: Бүлэг тус бүрээс 1 хүнийг сонгон урьдчилан бэлтгэсэн ажиглалтын хуудас, ярилцлагын асуумжийн дагуу чанарын судалгааг авна.

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн

Судалгааны асуумж нь хүн ам зүйн мэдээлэл, КОВИД-19-ын талаарх мэдлэг, хандлага, дадал, хүн амын эрсдэлийн талаарх ойлголт, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, Мэдээ, мэдээллийн эх сурвалж гэсэн хэсгүүдтэй.

Мэдээлэл цуглуулалт

Зорилтот эх олонлогоос түүвэрлэгдсэн иргэд хамруулан урьдчилан боловсруулсан асуумжийг ашиглан утсаар холбогдож, Google form-р өгсөн линкэнд мэдээллийг цуглуулна. Мэдээлэл цуглуулалтад 18 сумын эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан, улаан загалмайн нийгэмлэгийн 2 ажилтан, нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн 7 мэргэжилтэн эхний судалгааг 2022 оны 03-р сарын 02-ны өдрөөс 05-ны хооронд, дараах судалгааг 2022 оны 06-р дугаар сарын 13-ны өдрөөс 18-ны хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Судалгаанд хэрэглэх асуулгын хуудас нь дараах 8 бүлэгтэй байна.

- Хүн ам зүйн мэдээлэл (9 асуулт)
- Коронавируст халдварын талаарх мэдлэгийг үнэлэх (7 асуулт)
- Коронавируст халдварын талаарх хандлагыг үнэлэх (6 асуулт)
- Коронавируст халдварын талаарх дадлыг үнэлэх (16 асуулт)
- Хүн амын эрсдэлийн талаарх ойлголтыг судлах (14 асуулт)
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ (3 асуулт)
- Мэдээллийн эх сурвалж (3 асуулт)

Чанарын судалгаанд хэрэглэх ярилцлагын удирдамж нь дараах үндсэн асуудлуудыг багтаасан байна

- КОВИД-19-ын халдвар дамжих зам, шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг
- КОВИД-19-ын халдварын эрсдэлийн талаарх ойлголт, өвчлөх эсэх, өртөх магадлал, өвдлөө гэхэд хүнрэх эрсдэлийн талаарх ойлголт
- КОВИД-19-тэй холбоотой хувь хүн, айл, нийгэмд гарч буй эерэг, сөрөг нөлөөллүүд
- КОВИД-19-тэй холбоотой мэдээллийг хаанаас авч байна, ямар мэдээлэл хэрэгтэй байдаг талаар

Мэдээллийн чанар

- Түүврийн нэгжийн жагсаалтыг бүрэн бэлтгэх, сонгогдсон нэгжийг судалгаанд заавал хамруулах
- Асуулгын хуудас болон зааварт заасан чиглэлийн дагуу мэдээллийг цуглуулна. Мэдээлэл цуглуулах явцад ойлгомжгүй зүйл, бэрхшээл тулгарсан үед зөвхөн судалгааны ахлагчтай зөвлөлдөж, асуудлыг шийдэх байдлаар ажиллана.

Мэдээлэл боловсруулалт

Тоон судалгааны статистик боловсруулалтыг Google form болон SPSS программыг 23 хувилбарыг ашиглан өмнөх болон дараах судалгаанд харьцуулалт хийнэ.

Чанарын мэдээллүүдийг ангилах арга зүйг баримтлан боловсруулна. Үүний дараа үнэлгээний удирдамжийн дагуу багц кодыг боловсруулж бүх ярилцлагуудыг кодлоно. Кодлолтоор нийтлэг болон ялгаатай хүчин зүйлд үндэслэн дүн шинжилгээ хийнэ.

Хувь хүний мэдээллийг зөвхөн судалгааны ажилд ашиглах бөгөөд судалгааны үр дүнг мэдээлэхдээ хувь хүний нууцыг хадгална.

Хүлээгдэж буй үр дүн

- Хүн амын дундах коронавируст халдвар /КОВИД-19/-ын талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадлыг судалсан байна.
- Коронавируст халдвар /КОВИД-19/ дамжих зам, шинж тэмдэг, урьдчилан сэргийлэлт, хаана хандах талаар мэдлэгийг үнэлсэн байна.
- Судалгаанд хамрагдсан иргэдийн коронавируст халдвар /КОВИД-19/-ын талаарх хандлагыг тогтоосон байна.
- Хүн амын дундах коронавируст халдвар /КОВИД-19/-ын талаарх мэдээллийн эх сурвалж, хэрэгцээт мэдээлэл, цаашид ямар мэдээллийн эх сурвалжийг ашиглах талаар тогтооно.

-oOo-